



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/107/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын Санхүүгийн аудитын хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetseg@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Голден пэйж Аудит ХХК Захирал: С.Оюунгэрэл Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024-03-13 № 695
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЦЭЦ ДО ӨЭМТ-ИЙН ДАРГА
М.ЭНХМАНЛАЙ ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь сөрөг дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө материаллаг бөгөөд түгээмэл тархсан байна. Үүнд:

- Тус ӨЭМТ-ийн дарга, нягтлан бодогч, их эмч, нярав гэсэн 4 ажилтанд шагнал, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлс 103.7 сая төгрөгийг үнэн зөв тооцоолж олгоогүй;
- Эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийн орлогоос нягтлан, нярвын түрээсийн байрны зардалд 1.8 сая төгрөг зарцуулсан;
- Өөрийн үйл ажиллагааны 14.4 сая төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд дутуу тусгасан, хувь хүний дансаар болон бэлнээр хүлээн авдаг, санхүү бүртгэлд хяналт хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.2, 41.2.2, 44.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3, 5.1.4, 14.4.5, 19.1-д заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга ба тодруулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 770.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цэц до ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/548 захирамжаар 100.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах гэрээний биелэлтийг 92.7 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,562,782.95	2,568,822.16
Дансны авлага	60,252,927.98	15,964,385.50
Бусад авлага		
Бараа материал	13,439,699.00	38,329,625.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	75,255,409.93	56,862,832.66
Үндсэн хөрөнгө	264,459,255.93	274,665,332.19
Биет бус хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	264,459,255.93	274,665,332.19
Нийт хөрөнгийн дүн	339,714,665.86	331,528,164.85
Өр төлбөр ба эздийн өмч		
Дансны өглөг		
ХХОАТатварын өр		
НДШ-ийн өглөг	97,733.73	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	97,733.73	-
Өр төлбөрийн нийт дүн	97,733.73	-
Өмч	25,846,048.89	25,846,048.89
Төрийн	25,846,048.89	25,846,048.89
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
Хуримтлагдсан ашиг	313,770,883.24	305,682,115.96
Эзэмшигчдийн өмчийн дүн	339,616,932.13	331,528,164.85
Нийт өр төлбөр ба эздийн өмч	339,714,665.86	331,528,164.85

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Борлуулалтын орлогын дүн	879,321,607.39	1,113,604,340.57
Түрээсийн орлого (Санхүүжилтийн орлого)	729,311,202.74	1,075,565,012.91
Хүүний орлого	125,361.32	260,556.66
Бусад орлого (үнэгүй орлого, бусад)	149,885,043.33	37,778,771.00
Ерөнхий удирдлагын зардал		
Хандив тусламжийн орлого		
Ерөнхий удирдлагын зардал	712,013,893.31	1,121,693,107.85
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	167,307,714.08	(8,088,767.28)
Татварын дараах ашиг (алдагдал)	167,307,714.08	(8,088,767.28)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	167,307,714.08	(8,088,767.28)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Мөнгөн орлогын дүн	686,265,754.08	1,121,713,986.05
Татаас санхүүжилтийн орлого	599,814,142.76	1,119,803,429.39
Бусад мөнгөн орлого	86,451,611.32	1,910,556.66
Мөнгөн зарлагын дүн	675,187,850.13	1,087,342,446.84
Ажиллагчдад төлсөн	419,179,586.00	657,773,522.04
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	117,104,174.13	180,941,834.13
Бараа материал худалдан авахад төлсөн	89,484,677.00	113,692,671.00
Ашиглалтын зардалд төлсөн	1,639,500.00	1,914,168.00
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,790,050.00	7,618,100.00
Татварын байгууллагад төлсөн	43,474,014.00	70,731,355.00
Бусад мөнгөн зарлага	515,849.00	54,670,796.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,077,903.95	34,371,539.21
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
Мөнгөн зарлагын дүн	11,198,000.00	33,365,500.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	11,198,000.00	33,365,500.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(11,198,000.00)	(33,365,500.00)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(120,096.05)	1,006,039.21
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,682,879.00	1,562,782.95
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,562,782.95	2,568,822.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25,846,048.89	146,463,169.16	172,309,218.05
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-
Залруулсан үлдэгдэл	25,846,048.89	146,463,169.16	172,309,218.05
Тайлант үеийн ашиг		167,307,714.08	167,307,714.08
Бусад дэлгэрэнгүй орлого			
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25,846,048.89	313,770,883.24	339,616,932.13
Тайлант үеийн ашиг		(8,088,767.28)	(8,088,767.28)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	25,846,048.89	305,682,115.96	331,528,164.85

Гурав. Аудитын илрүүлэлт: Аудитаар нийт 121,489.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 105,738.9 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт, 14,369.6 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,380.7 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өглөө.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	1,380.7					1	1,380.7
Эрүүл мэндийн төвд хуваарилсан санхүүжилтийн орлогоос нягтлан, нярвын байрны түрээсийн зардал зарцуулсан	1	1,800.0	1	1,800.0				
Нягтлан бодогч илүү цаг, шагнал урамшуулал, хийснээр цалин нийт 25,774.2 мянган төгрөгийг шалгуургүй, шударга бусаар өөртөө давуу байдал үүсгэн үндэслэлгүй илүү тооцоолон авсан байна.	1	25,774.2	1	25,774.2				
Дарга, нийгмийн ажилтан илүү цаг, шагнал урамшуулал, хийснээр цалин нийт 40,277.5 мянган төгрөгийн шалгуургүй, шударга бусаар албан тушаалын давуу байдлыг ашиглан, үгсэн нэгдэж зүй бусаар үндэслэлгүй илүү тооцоолон авсан байна.	1	40,277.5	1	40,277.5				
Нярав илүү цаг, шагнал урамшуулал, хийснээр цалин нийт 15,633.6 төгрөгийг шалгуургүйгээр үндэслэлгүй зүй бусаар илүү олгосон байна.	1	15,633.6	1	15,633.6				
Их эмч илүү цаг /энгийн/, илүү цаг /баяр ёслолын/, шагнал урамшуулал, хийснээр цалин нийт 22,253.6 төгрөгийг шалгуургүй, шударга бусаар албан тушаалын давуу байдлыг	1	22,253.6	1	22,253.6				

ашиглан, үгсэн нэгдэж зүй бусаар үндэслэлгүй илүү тооцоолон авсан байна.								
2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг дүгнэлт авсан тул хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.	1				1			
Өөрийн туслах үйлчилгээний орлогыг бүртгэж тайлагнаагүй байна.	1	14,369.6			1	14,369.6		
Дүн	8	121,489.2	5	105,738.9	2	14,369.6	1	1,380.7

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд гүйлгээг дутуу мэдээлсэн байна.	1	33,300.0					1	33,300.0
Дүн	1	33,300.0					1	33,300.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг төлөвлөөгүй хөрөнгө худалдан авсан	1	137,893.4					1	137,893.4
Сангийн санхүүжилтийн орлогоос ашиглалтын зардалд зарцуулсан.	1	24,019.1					1	24,019.1
Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг бүртгэж тайлагнаагүй байна.	1	359.4					1	359.4
Дүн	3	162,271.9					3	162,271.9
Дүн	4	195,571.9					4	195,571.9

